



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 28 өдөр Дугаар 29

Хэрлэн сум

ХХІХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Халхгол сумын хилийн Баянхошуу боомтын Мэргэжлийн хяналтын газрын ажилтан, ажиллагсдын байрны өргөтгөлийн барилгын ажлыг хүлээж авсан тухай материалыг танилцуулах:

*Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт,  
хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ*

2.Монгол улсын Шадар сайдын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тушаал “/COVID-19/ халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага, сургууль зохион байгуулах тухай” танилцуулах:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын  
газрын дарга, хурандаа Г.Нармандах*

3.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн тайлан, байгууллагуудын ирүүлсэн санал:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын  
газрын дарга, хурандаа Г.Нармандах,  
Бүсийн оношлогоо эмчилгээний  
төвийн дарга Д.Должин*

4.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор намрын улиралд, Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумын хилийн заагаар босоо болон хэвтээ тэнхлэгийн чиглэлд харлуулсан цурам татах ажлын зураглал, шаардагдах хөрөнгийн тооцоог танилцуулах:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын  
газрын дарга, хурандаа Г.Нармандах*

5.Баян-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 53 дугаар ангид гамшгийн үед холбоо зохион байгуулах зориулалттай хэт богино долгионы станцыг худалдан авах, сумдад түймэр унтраах үлээгч аппарат худалдан авч нөхөн хангалт хийх тооцоог тус тус гаргаж танилцуулах:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах*

6.“Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ыг танилцуулах:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа*

7.Хилийн боомтод ажиллаж буй албан хаагч нарын онцгой нөхцөлд ажиллах хөдөлмөрийн нөхцөл, норм стандартыг танилцуулах:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа*

8.Аймгийн Онцгой комиссоос гарсан хурлын шийдвэрүүдийн биелэлтийн талаар танилцуулах:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах*

#### ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга,Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Дамдинбазар нарт:

1.1.Халхгол сумын хилийн Баянхошуу боомтын Мэргэжлийн хяналтын газрын ажилтан, ажиллагсдын байрны өргөтгөлийн барилгын ажлыг дутуу хүлээлгэн өгсөн тухай асуудлыг 14 хоногийн хугацаанд багтаан шийдвэрлэж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

1.2.Сумд болон мэргэжлийн байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгслээр үе шаттай хангах ажлыг судалж хэрэгжүүлэхийг,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

2.1.2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдах “/COVID-19/ халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлыг хангах дадлага, сургуульд Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг идэвхитэй оролцуулахыг,

2.2.2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдах “/COVID-19/ халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлыг хангах цахим дадлага, сургуульд оролцох 15 байгууллагын 32 албан хаагчийн хоолны зардал 2,016,000

төгрөг, бичиг хэргийн зардал 100,000 төгрөг, нийт зардал 2,116,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

3.1.Аймгийн Цагдаагийн газраас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу ариутгалын бодис шүршигч /автомакс/ 1 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Цагдаагийн газарт олгохыг,

3.2.Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүсийн оношлогоо эмчилгээний төвд чацаргана 30 кг, Мэргэжлийн хяналтын газарт чацаргана 10 кг, Эрүүл мэндийн газарт чацаргана 10 кг, Цагдаагийн газарт чацаргана 10 кг, Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт 10 кг чацарганыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

3.3.Коронавируст халдвар (COVID-19)-ийн үед Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн тусгаарлалтын байранд хяналт тавих, ажиглалт хийх камер хяналтын төхөөрөмжийн бүрдэл, камер 9 ширхэгийг худалдан авах зардал 2,970,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн оношлогоо эмчилгээний төвд олгохыг,

3.4.Бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хог хаягдлыг цэвэрлэх ажилд шаардлагатай 220 ширхэгийг бээлийний зардал 440,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Хэрлэн сумын Онцгой комисст олгохыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ нарт:

4.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор намрын улиралд, Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумын хилийн заагаар босоо болон хэвтээ тэнхлэгийн чиглэлд харлуулсан цурам татах ажлын зардал 6,831,300 төгрөгийг Гамшгаас хамгаалах зардал, аймгийн Засаг даргын нөөцийн сангаас тус тус шийдвэрлэхийг,

4.2.Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумын хилийн заагаар босоо болон хэвтээ тэнхлэгийн чиглэлд харлуулсан цурам татах ажлын зардал 10,0 сая төгрөгийг цаашид жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг,

Тав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

5.1.Сумдын Засаг дарга нарт ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журмын дагуу ажлын хэсэг байгуулж ажиллах, Монгол Улсын Засгийн газрын 106 дугаар тогтоолыг баримталж ажиллах тухай албан бичиг хүргүүлэхийг,

5.2.Халхгол сумын хилийн Баянхошуу боомтод ажилладаг мэргэжлийн хяналтын байцаагч нарт илүү цагийн мөнгийг олгуулах, 2021 оны төсөвт суулгуулах тухай албан бичиг, хүсэлтийг боловсруулж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаас Улсын Онцгой комисс, Монгол Улсын Шадар сайд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэхийг,

Зургаа.Сумдын Засаг дарга, агентлаг, аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт:

6.1.Аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрүүдийн биелэлтийг 1 хуудсанд багтааж 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаас өмнө Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг,

Долоо.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн-д:

7.1.Монгол Улсын Засгийн газар, Онцгой комиссоос гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой захирамж, шийдвэрийг цаг алдалгүй гаргаж ажиллах эрх олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА